

Аудитын код: САГ-2018/791/СТА-ТХН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamyia@audit.gov.mn

Ахлах аудитор Р.Цолмон
Утас: 260512 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

Аудитор Б.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaab@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Авлагын тооцооны талаар	4
2.9.2	Авлагын бүртгэлийн талаар	4
2.9.3	Авлагын тооцооны талаар.....	4
2.9.4	Бараа материалын зарцуулалтын талаар	4
2.9.5	Үндсэн хөрөнгийн талаар.....	5
2.9.6	Санхүүжилтийн орлогын талаар	5
2.9.7	Төсвийн гүйцэтгэлийн талаар.....	5
2.9.8	Зардлын талаар	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
3	Менежментийн захидал	8
3.1	Авлагын тооцооны талаар	9
3.2	Үндсэн хөрөнгийн талаар.....	10
3.3	Төсвийн гүйцэтгэлийн талаар.....	11
3.4	Зардлын талаар	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/435
танай _____-ны № _____-т

ЭМЯ, ГЛОБАЛЬ САНГИЙН
ДЭМЖЛЭГТЭЙ СҮРЬЕЭГИЙН
ТӨСЛИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
ЭМЯ-НЫ САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.НАРАНТУЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн санхүүгийн тайланд:

- Гадаадын байгууллагаас авах авлагаар тайлагнасан 2,998,887.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, авлага бууруулах тооцооллыг буруу бүртгэж, тайлагнасан,
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас худалдан авалтын буцаалт 153,084.7 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүй, баталгаажуулаагүй,
- Батлагдсан төсвийг зарим бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулсан. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардал 126,467.7 мян.төг, томилолт зочны зардал 73,592.2 мян.төг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 38,887.4 мян.төг-өөр тус тус хэтрүүлэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн "оршин байх", "эрх ба үүрэг", "тохиолдсон байх", "иж бүрэн байх", "үнэлгээ", "хэмжилт", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгж нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн төсвийн шууд захирагч ЭМЯ-ны Санхүүгийн хэлтсийн дарга Д.Нарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, хөрөнгийн ашиглах, шилжүүлэх талаар шийдвэр гаргуулах, зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 07-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор Б.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2018 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 18/029 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгж нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах журам”, 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Төслийн зорилго: Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, өвчтөн-төвтэй нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж, хэвшүүлэх, эмийн тэсвэртэй сүрьеэгийн аюулд анхаарал хандуулан, 2020 он гэхэд 2014 оны үзүүлэлттэй харьцуулснаар сүрьеэгийн тархалтыг 4%-иар, нас баралтыг 30%-иар бууруулах зорилготой байна.

Зорилтот бүлэг: Орон гэргүй сүрьеэтэй өвчтөнүүд, хоригдлууд, шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн амын бүлэг, алслагдсан нутгийн хүн ам, олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнүүд, ХДХВ-ийн халдвартай өвчтөнүүдэд илүү хүрч үйлчлэх.

Үндсэн үйл ажиллагааны чиглэл:

- Сүрьеэ өвчний оношлогоо илрүүлэлтийг сайжруулах,
- Сүрьеэ ХДХВ-ийн хавсарсан халдварын тусламж үйлчилгээ үзүүлэх,
- ОЭТС-ийн тусламж үйлчилгээ үзүүлэх,
- Эрүүл мэндийн мэдээллийн систем ба хяналт, шинжилгээ үнэлгээ явуулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 28 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгж нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “винница” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжид дотоод хяналтын чиг үүрэг бүхий алба нэгж алга байна. ЭМЯ-аас тайлант 2017 онд дотоод хяналт шалгалт хийгээгүй, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Глобаль сангаар батлуулсан 2017 оны төсвийг Худалдаа хөгжлийн банк дахь долларын харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгж нь 2017 онд Глобаль сангаас буцалтгүй тусламжийн санхүүжилт 3,670,829.4 мянган төгрөг, бусад орлого 153,081.7 мянган төгрөг, хүүгийн орлого 15,628.3 мянган төгрөг, нийт 3,839,539.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 3,916,394.2 мянган төгрөгийн зарцуулж ажилласан байна.

Мөн тус сангаас хандив тусламжаар 3,807,249.7 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр 42,394.2 мянган төгрөгийн нийт 3,849,643.9 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах шаардлагатай мэдээллийг мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны цахим мэдээллийн санд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан байна. тайланг оруулсан байна. Тайлант онд Нийцлийн аудитын газраас шилэн дансны шалгалт орж, шийдвэрийн хуулбар хавсаргаагүй байсан мэдээллийг нөхөж оруулсан.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 28 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Авлагын тооцооны талаар

Гадаадын байгууллагаас авах авлагаар тайлагнасан 2,998,887.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, авлага бууруулах тооцооллыг буруу бүртгэж, тайлагнасан.

Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэл, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөх;

2.9.2 Авлагын бүртгэлийн талаар

Авлагын дансанд валютын ханшийн бодит олз 19,935.5 мянган төгрөгийг бүртгэж, авлагыг хаасан байна.

Энэ нь УССНББОУС-4-ийн 57-д “Гадаад үйл ажиллагааг данснаас хасах үед тухайн гадаад үйл ажиллагаатай холбоотой үүссэн ханшийн зөрүүний хуримтлагдсан дүнг бусад цэвэр хөрөнгө/ өмчийн тусдаа бүрэлдэхүүн байдлаар хүлээн зөвшөөрч, данснаас хасалтын олз, гарзыг ашиг эсвэл алдагдалд хүлээн зөвшөөрнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

2.9.3 Авлагын тооцооны талаар

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас худалдан авалтын буцаалт 153,084.7 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүй, баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гархаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг мөрдөж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.4 Бараа материалын зарцуулалтын талаар

Завсрын аудитаар бараа материалын түүвэр тооллогыг 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар хийхэд 429,894.2 мянган төгрөгийн үнэ бүхий бага оврын хөргөгч, оношлуур, зөөврийн дижитал аппарат гэх зэрэг бараа материал дутагдсан, дансны үлдэгдэлд бүртгэлтэй нийт 3,404,269.0 мянган төгрөгийн бараа материалаас 3,043,412.3 мянган төгрөгийн өртөгтэй эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зэргийг салбар хүлээн авагчдад тушаал шийдвэргүйгээр олгосон.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ..., аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.1.1 “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитын үр дүнд жилийн эцсийн санхүүгийн тайлан гарахад тушаал шийдвэрийг нөхөн гаргуулж залруулсан.

2.9.5 Үндсэн хөрөнгийн талаар

Тус төслийн нэгжийн балансад бүртгэлтэй Ландкрузер тоёота-76 маркийн 50,652.8 сая төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхсөн автомашиныг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 249 дүгээр тушаалаар тус хөтөлбөр зохицуулах нэгжид ашиглах тушаал гарсан боловч ХӨСҮТ-д ашиглагдаж байна.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨТХ-д заасны дагуу авто машины ашиглалтын асуудлыг шийдвэрлүүлж, данс бүртгэлд тусгах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.6 Санхүүжилтийн орлогын талаар

Тайлант хугацаанд санхүүжилтийн 787.0 мянган төгрөгийн орлогыг валютын ханш буруу бүртгэснээс дутуу бүртгэсэн, 416,176.7 мянган төгрөгийг санхүүжилтийн орлогыг бусад орлогоор ангилал буруу бүртгэж, санхүүжилтийн орлогыг нийт 416,964.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэл, НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

2.9.7 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт батлагдсан төсвийг хэтрүүлээгүй боловч зарим зардал бүлгийн дүнгээр хэтэрсэн байна. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардал 126,467.7 мянган төгрөг, томилолт зочны зардал 73,592.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 38,887.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 4.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, тайлант хугацаанд эрх бүхий байгууллагаас батлагдсан төсөвт оруулсан аливаа өөрчлөлтийг баталгаажуулж байх, батлагдсан төсвийн хэмнэлттэй зарцуулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.8 Зардлын талаар

Мөнгөн хөрөнгийн журналаас түүврээр шалгахад төсвийг зориулалт бус зарцуулсан 10,356.5 мянган төгрөг, анхан шатны баримтын бүрдэл дутуу 7,517.7 мянган төгрөг, нийт 17,867.2 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай, НББ-ийн тухай хуулийг мөрдөж, батлагдсан төсвийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

САГ-2018/791/СТА-ТХН

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц дараах чухал асуудал байна. Үүнд:

Аудитын хугацаанд тус төслийн нэгжийн 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн баримтыг ЭЦГ-ын эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт шалгаж байгаагаас үзэх боломжгүй байлаа.

Тус төслийн нэгжийн авлагын тооцоо, гадаад харилцагчаас ирүүлсэн бүртгэлээс зөрүүтэй байгаа бөгөөд залруулсан аудитын тайланг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас нарийвчлан шалгах боломжгүй байлаа.

Тайлант хугацаанд тус төслийн нэгжээс салбар харилцагч байгууллагуудад олгосон санхүүжилтийг батлагдсан төсөв болон нэхэмжлэхийн дагуу олгосон бөгөөд уг санхүүжилтээр 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны цар хүрээний хэмжээгээр тархмал тул эрсдлийн аудитаар гүйцэтгэлийг үзэх шаардлагатай байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар тус төслийн нэгжийн гадаад харилцагч байгууллагатай нийлсэн тооцоо, авлагын барагдуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 6,939,751.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 3,480,311.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,459,439.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанаас 2,998,887.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 460,552.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд 2017 оны эхний хагас жилийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сууриас 2 хувиар тооцож 127,716.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзэв.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн санхүүгийн тайланд:

- Гадаадын байгууллагаас авах авлагаар тайлагнасан 2,998,887.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, авлага бууруулах тооцооллыг буруу бүртгэж, тайлагнасан,
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас худалдан авалтын буцаалт 153,084.7 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүй, баталгаажуулаагүй,
- Батлагдсан төсвийг зарим бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулсан. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардал 126,467.7 мян.төг, томилолт зочны зардал 73,592.2 мян.төг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 38,887.4 мян.төг-өөр тус тус хэтрүүлэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “оршин байх”,

“эрх ба үүрэг”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх”, “үнэлгээ”, “хэмжилт”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Авлагын тооцооны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас худалдан авалтын буцаалт 153,084.7 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүй, баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гархаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүд зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

- НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг мөрдөж ажиллах;

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.2 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус төслийн нэгжийн балансад бүртгэлтэй Ландкрузер тоёота-76 маркийн 50,652.8 сая төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхсөн автомашиныг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 249 дүгээр тушаалаар тус хөтөлбөр зохицуулах нэгжид ашиглах тушаал гарсан боловч ХӨСҮТ-д ашиглагдаж байна.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно” заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүд зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

- ТБОНӨТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2-т заасны дагуу холбогдох байгууллагаар уг авто машины ашиглалтын асуудлыг шийдвэрлүүлж, данс бүртгэлд тусгах;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.3 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт батлагдсан төсвийг хэтрүүлээгүй боловч зарим зардал бүлгийн дүнгээр хэтэрсэн байна. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардал 126,467.7 мян.төг, томилолт зочны зардал 73,592.2 мян.төг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 38,887.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 4.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулах, санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүд зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

- Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 4.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" заалтыг хэрэгжүүлж ажиллах;
- Тайлант хугацаанд эрх бүхий байгууллагаас батлагдсан төсөвт оруулсан аливаа өөрчлөлтийг баталгаажуулж ажиллах;
- Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах;
- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.4 ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Мөнгөн хөрөнгийн журналаас түүврээр шалгахад төсвийг зориулалт бус зарцуулсан 10,356.5 мянган төгрөг, анхан шатны баримтын бүрдэл дутуу 7,517.7 мянган төгрөг, нийт 17,867.2 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

ҮАГ-ын зөвлөмж

- Батлагдсан төсвийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх;

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг зардалд бүртгэхгүй байх;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/ төгрөгөөр /
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,687,976,211.94</u>	<u>3,879,636,944.33</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	960,687,445.28	860,760,781.18
Кассанд байгаа бэлэн мөнгө		
Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
Төгрөг	-	-
Гадаад валют	960,687,445.28	860,760,781.18
Арилжааны банк дахь харилцах	960,687,445.28	860,760,781.18
АВЛАГА	1,268,848,643.59	2,998,887,514.88
Байгууллагаас авах авлага	1,268,848,643.59	2,998,887,514.88
УРЬДЧИЛГАА	51,245,600.27	902,885.18
Урьдчилж гарсан зардал	51,245,600.27	902,885.18
БАРАА МАТЕРИАЛ	407,194,522.80	19,085,763.09
Хангамжийн материал	407,194,522.80	19,085,763.09
Эм боох материал	407,194,522.80	19,085,763.09
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16,849,602.98</u>	<u>24,513,621.50</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,849,602.98	24,513,621.50
Биет хөрөнгө	12,824,602.96	21,638,621.44
Авто-тээврийн хэрэгсэл	90,932,795.53	90,932,795.53
Хуримтлагдсан элэгдэл	(90,932,795.53)	(90,932,795.53)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,584,229.60	64,638,502.61
Хуримтлагдсан элэгдэл	(36,618,819.05)	(45,314,764.86)
Тавилга, аж ахуйн эд хогшил	17,359,681.21	17,359,681.21
Хуримтлагдсан элэгдэл	(14,500,488.80)	(15,044,797.52)
Биет бус хөрөнгө	4,025,000.02	2,875,000.06
Програм хангамж	4,600,000.00	4,600,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(574,999.98)	(1,724,999.94)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,704,825,814.92</u>	<u>3,904,150,565.83</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,704,825,814.92</u>	<u>3,904,150,565.83</u>
Засгийн газрын хувь оролцоо	2,704,825,814.92	3,904,150,565.83
Хуримтлагдсан үр дүн	2,704,825,814.92	4,319,742,447.72
Өмнөх үеийн үр дүн	2,281,668,732.97	2,704,825,814.92
Тайлант үеийн үр дүн	423,157,081.95	1,614,916,632.80
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	(415,591,881.89)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,704,825,814.92</u>	<u>3,904,150,565.83</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,020,642,618.13	9,172,719,665.13
ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,020,642,618.13	9,172,719,665.13
Нийтлэг татварын бус орлого	1,442,944,459.90	3,881,933,621.13
Хүүгийн орлого	12,369,466.98	15,628,338.60
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,265,223,099.20	3,670,829,395.62
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,265,223,099.20	3,670,829,395.62
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		42,394,227.72
Бусад орлого	165,351,893.72	153,081,659.19
Тусламжийн орлого	1,577,698,158.23	5,290,786,044.00
Хандив тусламж /дотоод/	1,577,698,158.23	5,290,786,044.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,797,113,902.15	4,100,679,184.16
УРСГАЛ ЗАРДАЛ	2,797,113,902.15	4,100,679,184.16
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,797,113,902.15	4,100,679,184.16
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	845,612,648.24	1,406,657,109.99
Үндсэн цалин	845,612,648.24	1,406,657,109.99
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,795,856.80	117,636,075.50
Гэрэл, цахилгаан	4,427,077.00	5,210,841.02
Цэвэр, бохир ус	769,471.00	-
Байрны түрээс	79,599,308.80	112,425,234.48
Хангамж, бараа материалын зардал	152,819,588.06	640,204,718.00
Бичиг хэрэг	8,283,851.00	55,469,432.00
Тээвэр, шатахуун	19,445,201.99	147,986,620.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,082,464.07	18,297,020.00
Ном, хэвлэл	114,008,071.00	281,437,501.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,014,145.00
Нормативт зардал	194,690,295.44	570,717,594.09
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,782,586.36	184,106,397.09
Хоол, хүнс	171,907,709.08	328,730,413.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		57,880,784.00
Эд хогшил, урсгал засварын зардал	161,578,889.84	99,074,440.15
Багаж, техник, хэрэгсэл	-	79,757,440.15
Урсгал засвар	161,578,889.84	19,317,000.00
Томилолт, зочны зардал	153,705,625.60	414,215,286.99
Гадаад албан томилолт	53,394,265.60	93,508,400.00
Дотоод албан томилолт	100,311,360.00	320,706,886.99
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,316,878.10	127,830,903.42
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,503,850.00	103,223,918.12
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	20,000,000.00
Даатгалын үйлчилгээ	2,600,000.00	3,475,882.00
Тээврийн хэрэгслийн татвар	360,600.00	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	852,428.10	1,131,103.30

Бараа үйлчилгээний бусад зардал	1,168,594,120.07	858,343,056.02
Бараа үйлчилгээний бусад зардал	634,068,328.00	196,353,890.43
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	528,073,351.74	651,598,911.10
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,452,440.33	10,390,254.49
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	223,528,715.98	5,072,040,480.97
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	209,005,996.68	497,250,927.11
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз	209,005,996.68	497,250,927.11
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,377,630.71	3,954,374,775.28
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	9,377,630.71	104,730,874.14
Үнэ төлбөргүй гарсан зардал		3,849,643,901.14
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	199,628,365.97	(3,457,123,848.17)
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	423,157,081.95	1,614,916,632.80

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгэ эний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
				Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2015.12.31-ний үлдэгдэл	-	-	2,281,668,732.97	-	2,281,668,732.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	423,157,081.95	-	423,157,081.95
2016.12.31-ний үлдэгдэл	-	-	2,704,825,814.92	-	2,704,825,814.92
2016.12.31-ний үлдэгдэл	-	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	(415,591,881.89)	(415,591,881.89)
Тайлант үеийн үр дүн	-	-	1,614,916,632.80	-	1,614,916,632.80
2017.12.31-ний үлдэгдэл	-	-	4,319,742,447.72	(415,591,881.89)	3,904,150,565.83

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,442,944,459.90	3,839,539,393.41
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,442,944,459.90	3,839,539,393.41
Нийтлэг татварын бус орлого	1,442,944,459.90	3,839,539,393.41
Хүүгийн орлого	12,369,466.98	15,628,338.60
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,265,223,099.20	3,670,829,395.62
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,265,223,099.20	3,670,829,395.62
Бусад орлого	165,351,893.72	153,081,659.19
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,819,955,858.74	3,916,394,228.59
УРСГАЛ ЗАРДАЛ	2,819,955,858.74	3,916,394,228.59
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,819,955,858.74	3,897,144,228.59
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	842,912,997.40	1,405,832,009.00
Үндсэн цалин	842,912,997.40	1,405,832,009.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,530,256.80	119,495,275.50
Гэрэл, цахилгаан	4,427,077.00	5,210,841.02
Цэвэр, бохир ус	769,471.00	-
Байрны түрээс	79,333,708.80	114,284,434.48
Хангамж, бараа материалын зардал	168,462,677.06	370,313,793.00
Бичиг хэрэг	8,443,700.00	52,831,082.00
Тээвэр, шатахуун	19,325,441.99	24,042,600.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,600,464.07	16,399,080.00
Ном, хэвлэл	129,093,071.00	258,819,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	18,222,031.00
Нормативт зардал	285,851,137.44	521,206,589.09
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	117,828,028.36	76,263,409.09
Хоол, хүнс	168,023,109.08	403,857,020.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		41,086,160.00
Эд хогшил, урсгал засварын зардал	199,054,706.00	96,776,522.15
Багаж, техник, хэрэгсэл	14,316,817.00	77,459,522.15
Урсгал засвар	184,737,889.00	19,317,000.00
Томилолт, зочны зардал	171,305,003.60	351,749,312.00
Гадаад албан томилолт	53,394,265.60	93,508,400.00
Дотоод албан томилолт	117,910,738.00	258,240,912.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,316,878.10	197,975,467.30
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,503,850.00	173,368,482.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	20,000,000.00
Даатгалын үйлчилгээ	2,600,000.00	3,475,882.00
Тээврийн хэрэгслийн татвар	360,600.00	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	852,428.10	1,131,103.30
Бараа үйлчилгээний бусад зардал	1,032,522,202.34	853,045,260.55
Бараа үйлчилгээний бусад зардал	537,320,136.32	209,153,859.55
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	495,202,066.02	643,891,401.00

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(1,377,011,398.84)</u>	<u>(76,854,835.18)</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,600,000.00	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,600,000.00	-
Гадаад эх үүсвэрээр	4,600,000.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4,600,000.00)</u>	<u>=</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бусад эх үүсвэр	209,005,996.68	80,587,051.03
Гадаад валютын ханшийн зөрүүний	209,005,996.68	80,587,051.03
Санхүүгийн үйл ажиллагааны зардал	9,377,630.71	103,658,879.95
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит	9,377,630.71	103,658,879.95
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>199,628,365.97</u>	<u>(23,071,828.92)</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)-(6)-(7)	<u>(1,181,983,032.87)</u>	<u>(99,926,664.10)</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,142,670,478.15	960,687,445.28
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	960,687,445.28	860,760,781.18

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		960,687,445.28		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,410,352,649.19	7,869,697,009.68	1,540,655,639.51	83.6
УРСГАЛ ЗАРДАЛ	9,410,352,649.19	7,869,697,009.68	1,540,655,639.51	83.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,410,352,649.19	7,869,697,009.68	1,540,655,639.51	83.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,555,859,556.65	1,405,832,009.00	150,027,547.65	90.4
Үндсэн цалин	1,555,859,556.65	1,405,832,009.00	150,027,547.65	90.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,485,017.25	119,495,275.50	(10,258.25)	100.0
Гэрэл цахилгаан	5,200,005.79	5,210,841.02	(10,835.23)	100.2
Байрны түрээс	114,285,011.46	114,284,434.48	576.98	100.0
Хангамж, бараа материалын зардал	385,379,119.52	370,313,793.00	15,065,326.52	96.1
Бичиг хэрэг	53,000,002.49	52,831,082.00	168,920.49	99.7
Тээвэр, шатахуун	24,895,300.00	24,042,600.00	852,700.00	96.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,401,023.64	16,399,080.00	1,943.64	100.0
Ном хэвлэл	269,815,161.82	258,819,000.00	10,996,161.82	95.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,267,631.57	18,222,031.00	3,045,600.57	85.7
Нормативт зардал	5,186,187,103.54	4,370,850,490.23	815,336,613.31	84.3
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,760,736,384.66	3,925,907,310.23	834,829,074.43	82.5
Хоол, хүнс	393,415,446.84	403,857,020.00	(10,441,573.16)	2.6
Зөөлөн эдлэл, нормын хувцас	32,035,272.04	41,086,160.00	(9,050,887.96)	28.2
Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,750,181.92	96,776,522.15	903,973,659.77	9.7
Багаж, техник хэрэгсэл	27,384,830.00	77,459,522.15	(50,074,692.15)	182.9
Урсгал засвар	973,365,351.92	19,317,000.00	954,048,351.92	2.0
Томилолт, зочны зардал	278,157,153.63	351,749,312.00	(73,592,158.37)	126.5
Гадаад албан томилолт	19,916,240.00	93,508,400.00	(73,592,160.00)	369.5
Дотоод албан томилолт	258,240,913.63	258,240,912.00	1.63	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	157,956,944.21	197,975,467.30	(40,018,523.09)	125.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,829,559.56	173,368,482.00	(47,538,922.44)	37.8
Аудит баталгаажуулалт	28,629,595.00	20,000,000.00	8,629,595.00	69.9
Даатгалын үйлчилгээ	3,497,789.65	3,475,882.00	21,907.65	99.4
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	-	1,131,103.30	(1,131,103.30)	
Бараа үйлчилгээний бусад зардал	726,577,572.47	853,045,260.55	(126,467,688.08)	117.4
Бараа үйлчилгээний бусад зардал	325,452,748.29	209,153,859.55	116,298,888.74	64.3

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	401,124,824.18	643,891,401.00	(242,766,576.82)	60.5
Бусад /Валютын ханшийн өөрчлөлт, бодит бус алд/		103,658,879.95	(103,658,879.95)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,410,352,647.56	7,769,770,345.58	1,640,582,301.98	82.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,410,352,647.56	7,769,770,345.58	1,640,582,301.98	82.6
Глобаль сангаас санхүүжих	9,410,352,647.56	3,670,829,395.62	5,739,523,251.94	39.0
Хөрөнгийн санхүүжилт		3,849,643,901.14	(3,849,643,901.14)	
Бусад орлого		153,081,659.19	(153,081,659.19)	
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз		80,587,051.03	(80,587,051.03)	
Хүүгийн орлого		15,628,338.60	(15,628,338.60)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	860,760,781.18		